

Илтгэлүүд

2009 оны олон улсын шашны эрх чөлөөний тухай илтгэл 2009 оны 10-р сарын 26

Монгол Улс

Үндсэн хуулинд шашны эрх чөлөөний талаар заасан бөгөөд бусад хууль тогтоомж, бодлогоор шашин шүтлэгийг ерөнхийдөө чөлөөтэй байлгахыг дэмждэг. Гэхдээ аливаа шашны байгууллага, лам санваартны бусдыг өөрийн шашинд оруулах үйл ажиллагааг хуулиар хязгаарласан.

Энэхүү тайлангийн хугацаанд Засгийн газрын зүгээс шашны эрх чөлөөг хүндэтгэх байдалд өөрчлөлт гараагүй. Орон нутгийн засаг захиргааны байгууллагын зүгээс шашны зарим бүлэгт хүнд суртал гаргаж, тэднийг бүртгэхээс татгалзах тохиолдол гарсан.

Шашин шүтлэгээс үүдсэн нийгмийн зүй бус харьцаа буюу шашин шүтлэгээр ялгаварлан гадуурхсан тохиолдлууд гарсны дотор Христийн шашинд орсон хүмүүсийг дарамталсан явдал гарчээ.

АНУ-ын Засгийн газар хүний эрхийг дэмжих ерөнхий бодлогынхоо хүрээнд тус улсын засгийн газартай шашны эрх чөлөөний асуудлын талаар санал бодлоо солилцдог.

I хэсэг. Шашны хүн ам зүй

Тус улс нийт 604,247 хавтгай дөрвөлжин миль нутаг дэвсгэртэй бөгөөд 2.7 сая хүн амтай. Буддын шашин нь тус улсын соёлын уламжлалтай нягт холбоотой. 1990 онд төр засгийн газар шашин шүтлэгийг хориглосон хоригоо цуцалснаас хойш Буддын шашны үйл ажиллагаа идэвхжин нэмэгдсэн. Орон нутгийн судлаачдын мэдэгдэж байгаагаар иргэдийн 90 гаруй хувь нь Буддын шашны ямар нэгэн хэлбэрт нэгдсэн боловч шүтлэгийн хэлбэр маш олон янз ажээ. Түвдийн Буддизмын шарын урсгал уламжлалт зонхилох шашин юм.

Ихэнх нь исламын шашин шүтдэг казахууд тус улсын хамгийн том үндэсний цөөнх юм. Казахууд улсын нийт хүн амын 5 орчим хувь, баруун зүгт орших Баян-Өлгий аймгийн хүн амын 80 хувийг тус тус эзэлдэг ажээ. Монголын мусульман шашинтны нийгэмлэгийн тооцоолсноор Монголд 135.000 исламын шашинт казах оршин сууж байгаа ажээ. Казахстан руу цагаачилсны улмаас казах иргэдийн тоо өнгөрсөн жилтэй харьцуулахад цөөрчээ. Исламын шашинтнууд 40 орчим мечеть, 7 исламын шашны сургалтын төв ажиллуулдаг бөгөөд эдгээр мечеть, сургалтын төвд нийт 3.000 орчим суралцагч Исламын шашинд суралцаж байгаа ажээ. Нийслэл Улаанбаатар хотод Исламын соёлын төв баригдаж байна. Исламын шашны мечеть, төвүүд Казахстан, Турк, Персийн булангийн улсуудын шашны байгууллагуудаас санхүүгийн тусламж авдаг.

Тус улсад цөөн боловч тоо нь улам нэмэгдэж буй Христийн шашинтан байдаг. Христийн шашны сүм хийдийн төлөөлөгчидийн тооцоолж байгаагаар Монголын нийт хүн амын 4-өөс илүү хувь нь Христийн шашин шүтдэг бөгөөд үүний 90% нь протестант, 9% нь Хожмын гэгээнтнүүдийн сүм хийдэд (мормончууд) харъяалагддаг ажээ. Ромын Католик болон Оросын үнэн алдартны шашинтнууд үлдсэн нэг хувийг эзэлдэг. Зарим иргэн өөр шашинтай хослуулан бөө мөргөлийг шүтдэг боловч бөө мөргөлтний тоог найдвартай гаргасан статистик мэдээ байхгүй.

Тус улс даяар 457 бүртгэлтэй сүм хийд байгаагаас 239 нь Буддын, 161 нь Христийн, 44 нь Исламын шашны, 5 нь Бахайн, 5 нь бөө мөргөлийн сүм хийд ажээ. Тайлангийн хугацаанд Хууль зүй, дотоод хэргийн яаманд (ХЗДХЯ) Христийн 18, Исламын 20, бөө мөргөлийн 3 сүм хийд нэмж бүртгэгджээ. Евангелийн Христүүд улс даяар бүртгэлгүй 250 Евангелийн сүм хийд байгаа болохыг тооцоолсон.

II хэсэг. Төр засгийн зүгээс шашны эрх чөлөөг хүндэтгэх байдал

Эрх зүй/бодлогын хүрээ

Үндсэн хуулинд шашны эрх чөлөөний талаар заасан бөгөөд бусад хууль тогтоомж, бодлогоор шашин шүтлэгийг ерөнхийдөө чөлөөтэй байлгахыг дэмждэг. Гэхдээ аливаа шашны байгууллага, лам санваартны бусдыг өөрийн шашинд оруулах үйл ажиллагааг хуулиар хязгаарласан. Бүртгүүлэхийг хүссэн шашны зарим бүлэг хүнд суртлын дарамттай тулгарч, хугацаа их алдах тохиолдол гардаг (Шашны эрх чөлөөг хязгаарлах байдлыг үз). Үндсэн хуулиар төр, сүм хийдийн тусгаар байдлыг илэрхий хүлээн зөвшөөрсөн.

Хэдийгээр тус улсад төрийн шашин байхгүй боловч Буддын шашинт төрийн албан хаагч олон хүн Буддын шашин нь тус улсын “уламжлалт шашин” гэж үздэг. Засгийн газар шашин, түүх, соёлын чухал төвүүд болох Буддын шашны хэд хэдэн сүм хийдийг сэргээн босгоход хөрөнгө мөнгөний туслалцаа үзүүлжээ. Засгийн газар Буддын шашныг болон өөр аливаа шашны бүлгийг үүнээс өөр байдлаар дэмжиж тэтгээгүй.

Шашны бүлэг хууль ёсны байгууллага болж үйл ажиллагаа явуулахын тулд Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлэх ёстой. 2008 оны сүүлээр Хууль зүй, дотоод хэргийн яам төрийн бус байгууллагуудыг (ТББ) бүртгэх (үүний дотор шашны байгууллагуудыг) үүргийг шинээр байгуулагдсан Улсын бүртгэлийн ерөнхий газарт (Ерөнхий газар) шилжүүлжээ. Бүртгэлийн хүчинтэй хугацаа нь 12 сар л байдаг учир шашны байгууллагууд жил бүр бүртгэлээ сунгуулах ёстой. Бүртгэлийг албан ёсоор гурван жил хүртэл хугацаагаар сунгаж болно. 2008 онд Засгийн газар Улаанбаатарт ажиллагаа явуулах дор хаяж 50 шашны байгууллагын бүртгэлийг нэг жилээр сунгажээ. Бүртгэл болон сунгалтын ажиллагаагаар дамжуулан Засгийн газар өргөдлүүдийг шалгаж, шашны мөргөлийн газар болон лам санваартны тоог хянаж, хязгаарлах боломжтой. Засгийн газар ялангуяа орон нутгийн түвшинд зарим үед бүртгэлийн ажиллагааг шашны мөргөлийн газрын тоог хязгаарлах механизм болгон ашигладаг.

Шашны бүлгүүд бүртгүүлэхдээ Ерөнхий газарт дараах баримт бичгийг бүрдүүлж өгөх ёстой: бүртгүүлэх өргөдөл, аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал буюу бусад эрх бүхий байгууллагаас шашны үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн бичиг, байгууллагын товч танилцуулга, байгууллагын дүрэм, байгууллагыг байгуулсан тухай баримт бичиг, удирдагчдын нэрсийн жагсаалт, санхүүгийн мэдээлэл, шашны үйл ажиллагаа эрхлэх хүний товч намтар, шүтэгчдийн тоо. Ерөнхий газар байгууллагын өргөдлийг батлах эцсийн эрх мэдэлтэй боловч, батлах ажиллагаа нь үндсэндээ ёс төдий юм. Практикт аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал өргөдлийг шийдвэрлэдэг бөгөөд ялангуяа шашны бүлгүүд хөдөө орон нутагт ажиллахыг хүсч байгаа тохиолдолд орон нутагт тусад нь бүртгүүлэх шаардлагатай. Аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал шашны үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгохдоо дээрхтэй төстэй бичиг баримт шаарддаг.

Засгийн газар тус улсад 90-ээс дээш хоногийн хугацаатай байх хувь хүмүүст шашны виз олгодог боловч өргөдлийг хянан шийдвэрлэх ажиллагаа нь цаг их авдаг бөгөөд 2008 онд дөнгөж 50 шашны виз олгогджээ.

Шашны бүх хувийн сургууль иргэний боловсрол олгох хөтөлбөртөө улсаас санхүүжилт авдаг. Засгийн газар шашны сургуулиудад шашны боловсролд нь зориулж улсын санхүүжилт олгох хориотой. Энэ бодлого бүх шашны бүлэгт ижил тэгш хэрэгждэг.

Шашны байгууллагууд үл хөдлөх хөрөнгийн татвар, нийгмийн даатгал төлөх ёстой. ТББ-ууд, үүний дотор шашны байгууллагууд орлогын албан татвар төлөх шаардлагагүй боловч нийслэлээс өөр газар байдаг шашны зарим байгууллага хуулийн энэ заалтыг мэдэхгүй, орлогын албан татвар төлж байлаа. Дипломат бус бүх байгууллага, хувь хүмүүс, үүний дотор шашны байгууллагууд гадаадаас оруулж ирсэн санхүүгийн бус бараа, үүний дотор хүнсний бараа, хувцас, эмнэлгийн хандивын бараанд гаалийн татвар, нэмүү өртгийн албан татвар (НӨАТ) төлөх ёстой.

Хуулийн дагуу гадаадын бүх байгууллага гадаадын ажилтан бүрийн тоогоор тодорхой тооны дотоодын иргэн ажиллуулах ёстой. Ажиллагсдын дунд дотоодын иргэдийн эзлэх ёстой хувь тухайн салбараас хамааран 60-95% байдаг. Энэ хууль нь шашны болон шашны бус байгууллагад аль алинд нь хамаарна. Шашны зарим байгууллага нийт ажиллагсад дунд дотоодын иргэдийн эзлэх хувь хэмжээг хуульд заасан хэмжээнд хүргээгүйн улмаас виз авахад хүндрэл гарч байсан.

Шашны эрх чөлөөг хязгаарлах байдал

Урьдчилан бүртгүүлэх болон жил тутам сунгуулах ажиллагаа нь хоёулаа шашны бүлгүүдэд дарамт болдог. Өргөдөл хянан шийдвэрлэх ажиллагаа хоёр долоо хоногоос, хэдэн жил хүртэл үргэлжилдэг тул бүртгүүлэх хүсэлтэй шашны байгууллагуудыг өргөдөл гаргахаас халшрахад хүргэдэг. Орон нутгийн албан тушаалтнууд Христийн сүм "хэт олон" байна гэх буюу шинээр бүртгүүлж байгаа

Буддын шашны болон Христийн шашны сүм хийдийн тоо ядаж ойролцоо байх ёстой гэж мэдэгдсэн хэмээн Христийн шашны бүлгүүд мэдээлсэн.

Улаанбаатарт ойрхон байдаг Төв аймгийн эрх баригчид Христийн сүм хийдийг бүртгэхээс байнга татгалздаг. Тус аймагт бүртгэлтэй Христийн сүм хийд нэг ч байхгүй. Төв аймгийн шашны нэгэн удирдагчийн хэлснээр тус аймагт бүртгэлгүй Евангелийн сүм 30 гаруй байгаа боловч аймгийн эрх баригчид нэгийг нь ч батлаагүй. Тайлангийн хугацаанд бүртгүүлэх өргөдөл гаргаад татгалзсан хариу авсан нэг сүм аймгийн эрх баригчдын эсрэг гомдол шүүхэд гаргажээ. Шүүх сүмийн талд шийдвэр гаргасан бөгөөд аймгийн эрх баригчид Улсын Дээд Шүүхэд давж заалдсан.

Бүртгэлгүй шашны байгууллагууд практикт их төлөв үйл ажиллагаа явуулах боломжтой байсан. Зарим байгууллага эрх баригчидтай харилцахад дарамт бэрхшээлтэй тулгардаг ба гадаадаас лам санваартан авчрахдаа виз авах боломжгүй байдаг гэж мэдээлсэн. Бүртгэлгүй сүм хийдэд орон нутгийн татварын байцаагчид болон цагдаагийн ажилтнууд байн байн ирж шалгалт хийн үйл ажиллагаанд нь дарамт учруулдаг. Гэхдээ ийм сүм хийдийг торгосон гэх мэдээлэл байхгүй. Түүнчлэн бүртгэлтэй сүм хийдүүдээс орон нутгийн эрх баригчид албан ёсны бичиг баримтаа үзүүлэхийг шаардаж, заримдаа хахууль нэхсэн гэсэн мэдээлэл байна. Энэ дарамт нь шашны сэдэлтэй, гадаадынхны эсрэг, эсвэл авлигатай холбоотой дарамт эсэх нь тодорхойгүй байв.

Бусад аймгууд дахь сүм хийдийн удирдагчид цөөн бэрхшээлтэй тулгарсанаа мэдээлсэн. Завхан аймаг дахь бүртгэлтэй Христийн шашны нэгэн сүм хийд орон нутгийн албан тушаалтнууд бүртгэлийн шаардлагыг хатуу мөрддөггүй болохыг мэдээлж байв. Увс аймаг дахь Христийн сүм хийдийн нэгэн удирдагчийн мэдээлснээр орон нутгийн засаг захиргааны албан тушаалтнууд тус сүмийн үзүүлдэг эмнэлгийн тусламжид талархаж, тус сүмтэй сайн харилцаа тогтоосон ажээ.

Улаанбаатар хот дахь Ислам шашинтнууд Дархан-Уул болон Орхон аймгуудад мечеть барихын тулд бүртгүүлж, газар авахад хүндрэл учирч байна хэмээн мэдэгдсээр байна. Гэхдээ тэд Улаанбаатар хотод Ислам шашны соёлын төв ба мечеть барих явцад ямар нэг асуудал гараагүй гэж мэдээлжээ.

Боловсролын яам удирдамж гарган гадаад хэлний буюу бусад сургалтыг шашны сургалттай хослуулахыг хориглосон. Энэхүү хориглосон журмын хэрэгжилтийг ялангуяа нийслэл хотод хатуу хянадаг. Гэхдээ тайлангийн хугацаанд энэхүү журмыг зөрчсөн тохиолдол бүртгэгдээгүй байна. Засгийн газар энэхүү хориглосон удирдамжийг зөрчсөн шашны бүлгүүдийн бүртгэлийг сунгахгүй байж болно. Түүнчлэн хичээл дээрээ шашин заасан багшийг ажлаас нь халах саналыг ажил олгогчид тавьж болно. Тайлангийн хугацаанд ийм тохиолдол гараагүй.

Шашны үзэл бодлыг түгээхдээ “хүчээр тулгах, шахалт үзүүлэх, эд мөнгөөр татах, хууран мэхлэх, тэдний эрүүл мэнд, ёс суртахуунд хохирол учруулах, санаа

сэтгэлийг үймүүлэхийг” хуулиар хориглосон. Тайлангийн хугацаанд энэ хуулийн дагуу албан ёсоор гомдол гаргасан тохиолдол байхгүй.

2008 оны 7-р сараас хойш Засгийн газар 70 орчим гадаадын шашны ажилтныг албадан гаргажээ. 2009 оны 2-р сард Нийслэлийн цагдаагийн газар Монголоос албадан гаргах гэж байгаа шашны ажилтнуудыг төлөөлсөн орон нутгийн өмгөөлөгчийг дөрвөн цагийн турш баривчлан саатуулсан. Тус өмгөөлөгчийг ямар ч хэрэгт яллаагүй боловч өмгөөлөгчийн мэдэгдэж байгаагаар түүнд торгууль ногдуулж, захиргааны арга хэмжээ авсан бөгөөд цаашид гадаадын шашны ажилтнуудыг төлөөлөхгүй байхыг анхааруулсан ажээ. Цагаачлалын албаны ажилтнууд түүний өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгуулах гэж оролдсон бөгөөд түүнийг ажлаас нь халахыг ажил олгогчоос нь хүсжээ. Тус өмгөөлөгч шүүхэд гомдол гаргахад шүүхээс цагдаагийн байгууллагыг хууль бусаар ажилласныг тогтоосон. Цагдаагийн байгууллага шүүхийн шийдвэрийг давж заалдсан бөгөөд тайлангийн хугацаа дуусахад энэ талаар шийдвэр хараахан гараагүй байв.

Орон нутгийн Христийн шашны байгууллагын мэдэгдсэнээр Боловсрол, Шинжлэх Ухаан, Соёлын Яам Лондон дахь Буддын шашны төвтэй хамтран дунд сургуулийн сурагчдад зориулсан Буддын шашны түүхийн гурван сурах бичиг гаргажээ. Тус Христийн шашны байгууллага Засгийн газар сурагчдад “шашны сурах бичиг” тараах замаар Буддын шашныг ивээж байна гэж гомдол гаргасан.

Тус улсад шашны хоригдол буюу шашин шүтлэгийн улмаас баривчлагдсан этгээд байхгүй.

Шашинд хүчээр оруулах

Шашинд хүчээр оруулсан, үүний дотор Америкийн Нэгдсэн Улсаас АНУ-ын бага насны иргэдийг хүчээр авч явсан, хууль бусаар гаргасан буюу ийм иргэдийг Америкийн Нэгдсэн Улсад буцаахыг хориглосон тохиолдол гараагүй.

III хэсэг. Нийгмийн зүгээс шашны эрх чөлөөг хүндэтгэх байдал

Энэ тайлангийн хамрах хугацаанд шашин шүтлэг дээр үндэслэсэн нийгмийн зүй бус хандлага, ялгаварлан гадуурхах тохиолдол хэд хэд гарсан. Христийн шашны сүм хийдийн эрх баригчдын мэдээлснээр Улаанбаатар хотод Христийн шашинтай гадаадын иргэд гэмт халдлага буюу бусад гэмт хэрэгт өртөж хохирсон тохиолдол олон гарсан боловч эдгээр гэмт хэрэг нь шашны сэдэлтэй байсан эсэх нь тодорхойгүй байна. Христийн шашны зарим удирдагчид эдгээр гэмт хэргийг шашны сэдэлтэй гэж үздэг боловч бусад нь гадаадын шашин номлогчдын эсрэг үйлдсэн гэмт хэргүүд Христийн эсрэг гэхээсээ илүү гадаадынхны эсрэг үзэл бодлоос үүдэлтэй гэж үздэг.

Буддын шашныг тус улсын “уламжлалт шашин” гэж итгэдэг зарим иргэд Христийн шашинтнууд хүмүүсийг эд хөрөнгөөр шашиндаа татдаг явдлыг шүүмжилдэг ажээ.

Орон нутгийн Христийн шашны ТББ-ын мэдээлснээр Христийн шашны сүм хийдийн буяны болон бүтээн байгуулалтын ажлын үр дүнд тус шашинд хандах орон нутгийн иргэдийн –хандлага сайжирч байна.

IV хэсэг. АНУ-ын Засгийн газрын бодлого

АНУ-ын Засгийн газар хүний эрхийг дэмжих ерөнхий бодлогынхоо хүрээнд тус улсын засгийн газартай шашны эрх чөлөөний асуудлын талаар санал бодлоо солилцдог. Тайлангийн хугацаанд АНУ-ын Элчин сайдын яамны албан тушаалтнууд шашны эрх чөлөөний асуудлаар Засгийн газрын албан тушаалтнуудтай орон нутаг, аймаг, улсын түвшинд санал бодлоо солилцсон. Эдгээр уулзалтаар АНУ-ын Засгийн газрын анхаарлыг татсан олон асуудлыг, үүний дотор Христийн болон бусад шашны бүлгүүд бүртгүүлэх явцад учирдаг бэрхшээлийн талаар ярилцсан. Элчин сайдын яамны албан тушаалтнууд Хүний эрхийн үндэсний комиссыг шашны эрх чөлөөг хэрэгжүүлэх асуудлаархи хүчин чармайлтаа өргөжүүлэхийг хөхиүлэн дэмжсэн. Тус Элчин сайдын яам НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссар ба НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн төлөөлөгчийн газартай байнгын харилцаа холбоотой байж, шашны эрх чөлөөны асуудлаар санал бодлоо солилцдог. Элчин сайдын яамны албан тушаалтнууд тус улсын шашны удирдагчидтай байнга уулздаг.